

БАТЛАВ:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН

ГАЗРЫН ДАРГА:

/Б.БУЯННЭМЭХ/

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“АЙСМАРК” ХХК-ийн захирал

/ П.ГАНЧИМЭГ /

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
18-Р ХОРООНД БАЙРЛАХ “АЙСМАРК” ХХК-ИЙН
“ЗАЙРМАГНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

/Л.ШИНЭЦЭЦЭГ/

БОЛОВСРУУЛСАН:

“АЙСМАРК” ХХК-ийн БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕР:

/Т.СУВДАА/

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас

Төсөл хэрэгжүүлэгч, хуулийн этгээдийн товч мэдээлэл

№	Мэдээлэлийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн нэр	“Айсмарк” ХХК
	Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Хүнсний үйлдвэрлэл
	Захиралын нэр, утас, цахим шуудан	П.Ганчимэг, 88880839, ganchimeg@teso.mn
	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудан	Т.Сувдаа, 88105955, environmental-manager@teso.mn
1.2	Төслийн нэр	Зайрмаг үйлдвэрлэл
	Төслийн харьяаллын байршил	СХД-н 18-р хороо энх тайвны өргөн чөлөө158/3
	Төслийн ангилал	Хамааралгүй
	Төсөл эхэлсэн огноо	2003
	Төсөл хэрэгжих хугацаа	-
	Уурхайн хаалт эхлэх огноо	Хамааралгүй
	Хаалтын дараах зориулалт	Хамааралгүй
	ТЭЗҮ батлагдсан огноо	Хамааралгүй
	Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ	-
	Ажилчдын тоо	310
	Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	-
	Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	Хамааралгүй

Химийн бодисын эрсдэл, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Мэдээлэлийн төрөл	Мэдээлэл
3.1	Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ	
	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө <ul style="list-style-type: none"> - Урьдчилан сэргийлэх арга хэмжээ - Эрсдлийн үед авах арга хэмжээ - Учирлуулах хор хөнөөлийг бууруулах зайлуулах арга хэмжээ - Хохиролыг нөхөн төлөх арга хэмжээ 	-
3.2	<ul style="list-style-type: none"> - Шатах тослох материалын нэр төрөл - Тэсрэх, дэлбэрэх бодисын нэр төрөл 	-
3.3	Тухайн жилийн хог хаягдлын дундаж хэмжээ <ul style="list-style-type: none"> - Ахуйн хаягдал - Үйлдвэрийн хаягдал - Аюултай хаягдал 	
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн төсөв	1100.0мян.төг

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2023 оны төсөв

№	Мэдээлэлийн төрөл	Мэдээлэл /мян.төг/
4.1	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	10.230.0
	Нөлөөллөөс урьдачлан сэргийлэх арга хэмжээний төсөв	5.550.0
	Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	
	Нөхөн сэргээх, ногоон байгууламж арга хэмжээний төсөв	3.100.0
	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	-
	Нөлөөллийн бүс дэхь оршин суугчидад тайлагнах төсөв	-
	Удирдлага зохион байгуулалтын төсөв	350.0
	Нүүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэх төлөвлөгөөний төсөв	-
	Орчны хяналт шинжилгээний нийт төсөв	480.0

Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дүн шинжилгээний хяналт

Байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	Тоо	Шалгуур үзүүлэлтийг тооцсон эсэх	Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тооцсон эсэх	Дүгнэлт
Нөлөөллөөс урьдачлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	7	Тийм	Тийм	
Нөлөөллийг бууруулах арга хэмжээ				
Нөхөн сэргээлт	-	-	-	
Дүйцүүлэн хамгаалах	-	-	-	
Оршин суугчидад тайлагнах	1	Тийм	Тийм	
Түүх соёлын өвийг хамгаалах	-	-	-	
Удирдлага зохион байгуулалт	1	Тийм	Тийм	

Орчны хяналт шинжилгээний хяналтын хуудас

Хяналт шинжилгээний дээж	Дээж авах цэгийн тоо	Дээж авах цэгийн байршил	Давтамж	Төсөв
Хөрс	2	Хашааны гадна хогийн цэгийн орчим, үүдний зогсоол орчим	Жилд 2	60.0мян.төг
Ус	1	Үйлдвэрийн хаягдал усны хоолой	Улиралд 1	120.0мян.төг
Амьтан	-	-	-	-
Ургамал	-	-	-	-
Агаар	3	Агуулахын байранд 2, гадна талбайд 1	Жилд 2	300.0мян.төг

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

№	Үндсэн мэдээлэл	Захиалагчийн мэдээлэл
1	Төсөл хэрэгжүүлэгч эзэмшигчийн нэр:	<i>Айсмарк ХХК</i>
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо 157-3 тоот
3	Улсын бүртгэлийн дугаар:	9011329119
4	Регистр:	5557747
5	Эзэмшиж буй газрын мэдээлэл:	10001м2, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 18-р хороо, үйлдвэрлэлийн зориулалттай, №000324213 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй,



Зураг № 1 Төслийн талбайн байршил



Хүснэгт № 1 Сансрын зураг

Төслийн талбайн нь улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах гэрчилгээний дугаар нь 18635310375457 дугаараар бүртгэгдсэн байгаа бөгөөд дараах солбилцолд байрлана. Үүнд:

Хүснэгт . Нэгж талбарын эргэлтийн цэгийн солбицол

Д/д	Газар зүйн солбицол		Тэгш өнцгийн солбицол		Талбай, м2
1	47° 54' 49.01"	106° 48' 37.26"	635267.18	5308284.98	10001
2	47° 54' 49.73"	106° 48' 37.01"	635261.34	5308307.13	
3	47° 54' 49.80"	106° 48' 36.61"	635252.95	5308309.12	
4	47° 54' 51.66"	106° 48' 36.08"	635240.70	5308366.24	
5	47° 54' 51.70"	106° 48' 36.51"	635249.69	5308367.74	
6	47° 54' 51.67"	106° 48' 37.50"	635270.10	5308367.12	
7	47° 54' 51.58"	106° 48' 39.42"	635310.01	5308365.28	
8	47° 54' 51.55"	106° 48' 39.44"	635310.42	5308364.60	
9	47° 54' 51.69"	106° 48' 40.66"	635335.82	5308369.28	
10	47° 54' 51.71"	106° 48' 40.97"	635342.06	5308370.21	
11	47° 54' 51.79"	106° 48' 41.09"	635344.49	5308372.78	
12	47° 54' 51.83"	106° 48' 41.33"	635349.47	5308373.94	
13	47° 54' 51.87"	106° 48' 42.10"	635365.47	5308375.61	
14	47° 54' 51.89"	106° 48' 42.21"	635367.68	5308376.43	
15	47° 54' 52.02"	106° 48' 42.73"	635378.46	5308380.64	
16	47° 54' 52.10"	106° 48' 43.48"	635393.85	5308383.53	
17	47° 54' 52.12"	106° 48' 43.57"	635395.80	5308383.96	
18	47° 54' 51.46"	106° 48' 43.76"	635400.26	5308363.88	
19	47° 54' 51.35"	106° 48' 42.94"	635383.34	5308360.12	
20	47° 54' 49.87"	106° 48' 43.36"	635393.05	5308314.54	
21	47° 54' 49.68"	106° 48' 41.84"	635361.62	5308307.89	
22	47° 54' 49.43"	106° 48' 39.82"	635320.01	5308299.20	
23	47° 54' 49.30"	106° 48' 38.95"	635302.05	5308294.87	

Тайлбар: Айсмарк ХХК-ны кадастрын зургаас .

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Байгалийн экосистемийн өөрчлөлт: Үйл ажиллагааны онцлог, байгалийн гамшигт үзэгдлийн улмаас хөрс, хөрсний усанд химийн бодис алдагдах, орчны агаарт хорт хий болж дэгдэх, ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх, үйлдвэрийн хаягдал ус нь ариутгах татуургын сүлжээнээс алдагдах, улмаар газрын доорх усны нөөц, чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт нөлөөлөх дам нөлөөлөл үүсч болзошгүй юм. Хяналтын хуудасны үр дүнгээс харахад хөрсний элэгдэл эвдрэл, агаарын бохирдолд шууд нөлөөлөх, гадаргын болон газрын доорх усны нөөц, чанар, хүний эрүүл мэнд, ургамлан нөмрөгт дам нөлөөлөх бөгөөд эдгээр нөлөөлөл дунд, сулавтар байхаар байна. Дээрх дам нөлөөллүүд нь голчлон үйлдвэрийн осол аваар, ажилчдын хайнга байдал, аюулгүй ажиллагааны дүрэм журмаа барьж ажиллахгүй байх, тоног төхөөрөмжийн буруу ашиглалттай холбоотойгоор үүсч болзошгүй бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх, аюул ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, хуримтлалтай ажиллах нь зүйтэй юм.

Байгалийн нөөцийн ашиглалт: Газрын доорх нөөц баялаг, эрдэс түүхий эдийн нөөцийн багасалтад нөлөөлөх нөлөөлөл нь байхгүй. Бэлчээрийн байдалд шууд бус нөлөөтэй, эрчмийн хувьд бага байна.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: Тоосжилтоос хамгаалах арга хэмжээг хангалтгүй авч хэрэгжүүлсэн тохиолдолд хөрсний болон агаарын бохирдол нэмэгдэх зэрэг шууд нөлөөлөл үүснэ. Энэ нөлөөлөл нь агаарын бохирдол, хөрсний бохирдолд бага эрчимтэй нөлөөлнө. Ингэснээр ойр орчмын хөрсний бүтэц өөрчлөгдөх улмаар ургамлын бүрхэвчид нөлөөлж болох таптай. Дуу чимээ, шуугианы нөлөөлөл нь дунд эрчимтэй шууд, богино хугацааны нөлөөлөлд багтах ба ажиллагсадын эрүүл мэндэд буцаж нөлөөлөх нөлөөлөлд хамрагдана.

Нийгэмд үзүүлэх нөлөөлөл: Үйлдвэрийн үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах бөгөөд ажлын байр бий болж, иргэдийн амьжиргаанд тус нэмэр болох, дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх, тэдгээрийг даган бий болох эерэг нөлөөлөл ихтэй юм. Эдгээр нь шууд бөгөөд урт хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна. Үйлдвэрийн үйл ажиллагаанаас нийгмийн харилцаа, бүлгүүдэд нөлөөлөх сөрөг нөлөөлөлд өртөгч талууд нь үйлдвэр болон төслийн талбайн ойролцоо амьдардаг оршин суугчид байх бөгөөд мах ангилах, боловсруулах технологи, тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотойгоор ажилчдын эрүүл ахуй, аюулгүй байдалд нөлөөлөл үүсч болзошгүй юм.

Байгалийн цогцолборг газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор: Үйлдвэрийн үйл ажиллагааны үед байгалийн өнгө төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх зэрэгт бага эрчимтэй, шууд бус удаан хугацаанд нөлөөлөхөөр байна. Төслийн талбайн ойр орчимд одоогийн байдлаар түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор илрээгүй байна.

Бусад нөлөөлөл: Энэ төрлийн нөлөөлөлд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй ахуйн болон үйлдвэрийн хатуу хог хаягдал, үйлдвэрийн шингэн хаягдалтай холбоотой нөлөөллийг хамруулна. Үйлдвэрийн болон ахуйн хатуу хог хаягдлыг Нүүрстийн аманд түр хугацаагаар булаах арга хэмжээ авч байгаа.

ГУРАВ.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн талбай нь Сонгинохайрхан дүүргийн 18 –р хорооны нутаг дэвсгэрт, үйлдвэрийн районд байрлаж байна. Газрын гадаргын төрх байдал нь үндсэндээ байгалийн унаган төрх байдлаа алдсан, хүн, техникийн нөлөөгөөр элэгдэл, эвдрэлд өртсөн байдалтай байна. Одоогийн байдлаар төсөл хэрэгжих талбайн бүрэн хатуу байна.

Ерөнхий үнэлгээнд тусгасаны дагуу төслийн байршилтай холбоотой асуудлыг тодруулах, тэдгээрийн төсөлтэй холбоотой байх шалтгааныг авч үзсэн бөгөөд тэдгээрээс төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна.

Хүснэгт 1. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй нөхцөлүүд
Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх	Байхгүй
Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх	Цаг уурын өөрчлөлтөд эмзэг, тухайлбал: Орон нутагт хүчтэй салхи шуурга болох магадлал ихтэй, салхи, шуурга болсон тохиодолд нөлөөллийн эрчим дунд зэрэг Үер, усны болзошгүй эрсдэл бага Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл бага.
Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх	Байхгүй.
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх хуримтлагдах нөлөөлөлд түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэх тээврийн хэрэгслийн болон тоосжилт, ажлын байрны физик бохирдол тус тус хамаарна.

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаварын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Барилга байгууламжуудаар газрын гадарга нөлөөлөлд өртөх	х			
2	Хатуу, шингэн хог хаягдал хөрсөнд алдагдаж, газрын гадарга бохирдож болзошгүй	х			
3	Байршилтай холбоотой нөлөө	х			
	Нийт	3			

Дүгнэлт - Нийт нөлөөллийн 100 хувь нь бага ангилалд багтаж байгааг үндэслэж тухайн төсөл хэрэгжих орчны газарзүй, ландшафт, байршил, геологи орчинд газрын хэвлий, газрын гадаргад **Бага** зэргийн эрчимтэй нөлөөлөл үзүүлэхээр байна гэж үзэв.

- 2.2 Агаарын чанар

Агаарын чанарын шинжилгээг дор дурдсан аргачлалуудаар гүйцэтгэж Агаарын чанарын MNS 4585 : 2016 стандартын техникийн ерөнхий шаардлагатай харьцуулан дүгнэдэг.

Агаар дахь хийн хольцын агууламжийг тодорхойлохдоо агаарыг сонгомол дэвтээгч уусмалаар цэнэглэсэн шингээгч гуурсанд 20 минутын турш соруулж аван азотын давхар исэл (NO₂)-ийг Грисс-Иловын аргаар, хүхэрлэг хий (SO₂) -г тетрахлортмеркуратын аргаар тус тус тодорхойлдог.

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM_{2.5}, PM₁₀ тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар болон химийн аргаар тодорхойлж байна.

2021 оны хүйтний улиралын эхэн үе 10 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг 2022 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM₁₀ тоосонцор 18 мкг/м³-ээр буюу 10 %-аар их байсан бол PM_{2.5} тоосонцор 29 мкг/м³-ээр буюу 19 % -аар бага, хүхэрлэг хий, азотын давхар исэл өөрчлөлтгүй байсан.

Хүснэгт 2. Агаарын чанарын үзүүлэлт

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2021 оны 10-р сар	2022 оны 10-р сар
PM ₁₀ тоосонцор	100	176	194↑
PM _{2.5} тоосонцор	50	149	120↓
Хүхэрлэг хий, SO ₂	50	49	47↔
Азотын давхар исэл, NO ₂	50	48	48↔

Тус төслийн талбай орчимд хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөр болон зөвшөөрөх хэмжээнээс хэтрэх нөхцөл үүсээгүй байна.

Агаар бохирдуулах үндсэн эх үүсвэрийг байгалийн гаралтай, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж 2 ерөнхий хэсэгт хувааж үздэг.

Төслийн үйл ажиллагаанаас хамааралтай агаарын бохирдолд нөлөөлөх сөрөг хүчин зүйл төдийлөн өндөр биш байна. Үйлдвэр болон агуулахын байр агааржуулалт сайтай, агааржуулалтыг зориулалтын мембран фильтр суурилагдсан. Агуулахын үйл ажиллагааны улмаас орчны хөрс эвдэрч тоосжилт нэмэгдэх, химийн бодис тээвэрлэх, ачих, буулгах, зөөх, үеийн сөрөг нөлөөлөл байхгүй гэж үзэж байна.

Харин хадгалах үеийн ууршилтаас гарах хий, хатуу бодисын тоос нь агаарын чанарт нөлөөлөх боловч хөдөлмөр хамгаалалын дүрмийг баримтлан ажилласнаар энэхүү нөлөөлөл маш бага байх болно.

Үйлдвэрийн байрны агааржуулалтын хэвийн ажиллагаа алдагдсанаас ажлын байрны агаар бохирдоно.

Үйлдвэрийн түүхий эдүүдийг тээвэрлэн ирж буулгах, бэлэн болсон бүтээгдэхүүнийг ачиж явах үед тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас гарах хорт хий, утаа гадна агаарын чанарт нөлөөлнө.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Химийн бодисын хадгалалт хэрэглээ	х			
2	Ажлын байрны агаарын бохирдол, үнэр, тоосжилт		х		
3	Үйлдвэрийн тоног төхөөрөмжөөс үүсэх дуу шуугиан	х			
	Нийт	2	1		
		66.7	33.3		

Хэсгийн дүгнэлт - Нийт нөлөөллийн 66.7 % нь Бага, 33.3 % нь Дунд гэсэн үнэлгээтэй байгаа нь агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл Бага зэрэг гэж дүгнэж байна.

Хөрсөн бүрхэв

Уг төсөл хэрэгжих талбай нь эргэн тойрондоо байшин барилга, хашаагаар хүрээлэгдсэн, Туул голын хөндийд байрладаг. Нийслэл хотын нутаг дэвсгэрийн 95.5% нь 4 дүгээр зэргийн, 4.5% нь 3 дугаар зэргийн бохирдолтой гарсан байна. Хөрс ийнхүү бохирдолтой байгаа нь ахуйн болон химийн гаралтай хог, хаягдлыг ил задгай, замбараагүй асгадгаас үүдэлтэй гэж үздэг.

Төслийн талбайд 1 үндсэн зүсэлт хийж 2 ш дээж авч, шинжилгээ хийлгэхээр “Инженер геодези” ХХК -ийн хөрсний лабораторид өгч дараах шинжилгээг хийлгэв.

Хөрсний үржил шимийн үзүүлэлт

Дээж авсан дүн	pH	cond	Давс	Ялзмаг	CO ₂	Солилцох суурь			Шим тэжээлийн үзүүлэлт		
						Ca	Mg	Нийлбэр	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
/ см /		dsm	%	%	%	мг-экв/100г			мг/100г		
0-5	8.6	0.217	0.10	1.64	1.15	11.9	4.2	16.1	0.06	1.6	8
5-20	8.2	0.078	0.04	1.19	0.82	8.0	3.1	11.1	0.09	1.2	11

Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлтийн дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % /мм –ээр/						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Зүсэлт -1	0-5	29.3	28.0	22.7	10.0	7.1	3.0	20.0
	5-20	53.8	28.5	6.8	0.4	6.7	3.8	10.9

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид дараах нөлөөлөл үүснэ.

- Үйлдвэрийн 2.2 га талбайн нийт хөрсний 90 % нь элэгдэл, эвдрэлд орж үндсэндээ устаж үгүй болсон бөгөөд хатуу цардсан зам талбайтай болно.
- Түүхий эд сав баглаа боодол ахуйн хог хаягдлыг ил задгай байршуулсанаас болон хатуу хог хаягдлын цэг орчим зэргийн улмаас хөрс бохирдож болзошгүй .
- Төслийн үйл ажиллагаатай холбоотой түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн улмаас талбайн гаднах талбайд шатах тослох материал алдагдах, тоосжилт үүсэх.
- Төслийн үйл ажиллагаатай холбоотой тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хог хаягдлыг хаях, ус зайлуулах суваг шуудуу татах барилга байгууламж барих гэх мэт үйл ажиллагаанаас үүдэн хөрсөн бүрхэвч шууд ба шууд бус байдлаар элэгдэл эвдрэлд өртөж талхлагдана. Элэгдэл, эвдрэлд орж суларсан хөрс шорооноос агаарын бохирдол үүсэх бас нэгэн нөхцөл болно.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Гол зорилго: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд улирал бүр тогтоосон цэгүүдээс орчны хяналт, шинжилгээний үзүүлэлтийг мэрэгжлийн байгууллагаар шинжлүүлж ЗДХ давсан үзүүлэлт илэрвэл судалж өөрчлөлтийн үндсэн шалтгааныг тодорхойлон цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, нийгтийн хариуцлагын хүрээнд байгаль хамгаалах үйл ажиллагаа нь олон нийтэд нээлттэй харияа засаг захиргаатайгаа хамтарч байгаль орчин болон тухайн бүсийн оршин суугчдыг аливаа сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлснээр илүү үндэслэлтэй болгох боломжтой юм.

Төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасаны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

“АЙСМАРК” ХХК

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал /Мян.төг/	Нийт зардал /Мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаар орчин						
Хөргүүрт ашиглах хөргөлтийн бодис	Орчны болон ажлын байрын агаарын бохирдолын байдалд жилд 1 удаа шинжилгээ хийх	Үйлдвэр, агуулахын хүрээнд	-	-	2023	
Хөрсний элэгдэлээс үүсэх тоосжилт, машин техникийн утаа	Үйлдвэрийн орчинд зориулалтын зогсоолоор бүрэн хангах	Агуулахад	-	1.000.0	2023	
2. Дуу чимээ						
Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлэх	Машин тоног төхөөрөмжийг дуу шуугиан хамгийн бага тарах нөхцөлтэйгээр байршуулан ашиглах	Агуулах, төв байранд	-	-	-	MNS ISO 226:2003 Дуу чимээ хэвийн норм түвшиний чимээ MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангах	Ажиллагсад	20.0	60 x 20.0 1.200.0	2023 онд	
	Дуу шуугианд хэмжилт хийх	Агуулах, төвийн байр	30.0	30x3 270.0	Жилд 3 удаа	
3. Усны нөөц, чанар						
Төслийн явцад усыг их хэмжээгээр, замбараагүй хэргэлснээр усны нөөцөд шууд нөлөөлөх магадлалтай	Усны нөөц хомсодхоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд			Тогтмол	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль -Усны тухай хууль

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“АЙСМАРК” ХХК

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Хөрс, ургамлан бүрхэвч						
Химийн бодис алдагдах, ажиллагсдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх:	хог хаягдлын цэгийг хатуу хучилттай болгох	Агуулах төвийн хүрээнд	-	1.500.0	2023 онд	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементийн нийт хэмжээг тодорхойлох арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Агуулах үйлдвэрийн гаднах талбайд цэвэрлэгээ арчилгааг тогтмол хийх	Агуулах төвийн хүрээнд	-	-	Тогтмол	
Химийн бодис болон ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох	Хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх	Төслийн хүрээнд	-	-	Сар бүр	
	Үйлдвэр, агуулахын гадна орчинг зүлэгжүүлэх, мод тарих	Үйлдвэрийн эргэн тойронд	6.5	200x6.5 1.300.0	2023 онд	
нийт			5.270.0			

ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Болзошгүй осол, саатал, техник технологийн болон шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх Байгалийн гамшиг, түүнээс урьдчлан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Техник технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Барилга байгууламж техник тоног төхөөрөмжид	ҮА зардалд	ҮА зардалд	Өдөр бүр тогтмол /инженерүүд/	Гамшгаас хамгаалах тухай хууль 27.1
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд бүх ажилчдад	500.0	2.000.0	Сургалтыг улирал бүрт 1 удаа	
	Химийн бодистой харьцаж ажиллах ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт зохион байгуулах		200.0	200.0	2023 онд	
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	ХХА зардал	-	2023 онд	
	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр /хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил маск/ хангах	Шйл ажиллагааны турш				
	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэрэгжлийн байгууллагаар тогтоолгох	Төслийн нийт хугацаанд	600.0		2023 онд	
НИЙТ			2.800.000			

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Жил бүр	350.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлаг зайлуулж буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж, засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих	Төслийн эхэн үед болон ашиглалтын үед	250.0	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Буцаалтаар устгаж байгаа бүтээгдэхүүнийг саармагжуулж шугам хаях мөн ариутгал цэвэрлэгээний бодисын үлдэгдэлд хяналт тавих	Төслийн хүрээнд	500.0	
Хийн хаягдал гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр бүрийн ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах		-	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
НИЙТ				1.100.0

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээлэлийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов
СХД-н 18-р хорооны иргэд	Уулзалт	БОМТ, хяналт шинжилгээ	10-11-р сар
Нийслэлийн байгаль орчны газар-т	Хэвэлмэл тайлан	БОМТ хэрэгжилт	11.01-ний дотор
БОАЖЯ-ны ХБОБНУ-ын газарт	Батлуулах	БОМТ-г батлуулах	Жил бүрийн 12 сард

2023 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Айсмарк” ХХК-ийн “Зайрмагны үйлдвэр” төслийн 2020-2025 оны хоорондох 5 жилийн Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангаас тухайн жилийн рчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгасан. Үүнд:

- ✚ Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл, хяналт-шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд, төрөл, хэлбэр;
- ✚ Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил, хугацаа, давтамж;
- ✚ Хяналт-шинжилгээ хийх арга, аргачлал, түүнд шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- ✚ Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал /мян.төг/	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар /Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх/	Үйлдвэр, агуулахын байранд 2 цэг, химийн бодисын гадна хашаанд 1 цэг	Агаарын найрлага улиралд 1 удаа	25.0x4 удаа x 3 цэг Нийт 300.0	MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384-1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048-1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:2008 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS ISO 226:2003 Дуу чимээ-Хэвийн норм MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Усны хяналт шинжилгээ	Хаягдал усны хоолойноос	Хагас жилд 1	30.0 x 2удаа Нийт 60.0	MNS ISO 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 13.060.50 Усны чанарын стандарт

“АЙСМАРК” ХХК

Хөрсний төлөв байдал. Бохирдол	Агуулах, үйлдвэрийн хашааны гадна Хатуу хог хаягдлын талбайн ойр тус бүр нэг цэг	Жилд 2 удаа	2 цэг х 2 дээж х 2 удаа х 20.0= 80.0 Хүнд металл 2 цэг х 1 дээж х 2 удаа х 20.0=40.0	MNS 3307:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалага, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлийн болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга
нийт зардал			480.0	

Нөхөн сэргээлт, орчны тохижилтын төлөвлөгөө

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм. "Айсмарк үйлдвэр"-ийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан моджуулах ажлыг БОННУ-ний тайлан тусгасан зөвлөмжийн дагуу тарих шаардлагатай.

Ер нь газрын нөхөн сэргээлт гэдэг нь "эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ" юм.

Жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болсон байна.

ОРНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Хэрэгжих байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал /мян.төг/
1	Үйлдвэрийн орчны тохижилт	Авто машин явах зам талбайн урсгал, чиглэлийг заах тэдэглэгээ	2,5жилд нэг удаа	100,000
2	Цэцэрлэгжүүлэлт, Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Ногоон байгууламж дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ /арчилгаа тордолгоо/	Жил бүр	3,000,000
2023 оны нийт зардал нийт				3,100,000